



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
“МОГОЙН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 06

Бүрхээр

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, “Могойн гол” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.10 дахь заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын Хорооны дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Могойн гол” ХК-ийн 2022 оны жилийн эцсийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1182 (нэг мянга нэг зуун наян хоёр) төгрөгийн ногдол ашиг хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1-т заасан ногдол ашгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн мөн оны 04 дүгээр сарын 21-ний өдөр хүртэлх хугацаанд нийт хувьцаа эзэмшигчдэд олгож дуусгахыг компанийн гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгасан цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1182 төгрөгийн ногдол ашиг хуваарилсан тухай тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал (Б.Батхүү) болон ерөнхий нягтлан бодогч (Т.Эрдэнэчимэг) нарт даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБОЛД